



2020.01.21

# “ДОРНОД БУСИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМ” ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИ

# ТАВИЛГА ЭД ХОГШИЛ НИЙЛҮҮЛЭХ ҮНИЙН САНАЛ АВАХ БАРИМТ БИЧИГ

## Төслийн нэр:

## Тавилга эд хогшил нийлүүлэх

## Харьцуулалт/

ДБЭХС/202001115

## Гэрээний дугаар:

Чойбалсан хот 2020 он

## Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

Огноо : 2020.01.31

Төслийн нэр: **Тавилга эд хогшил нийлүүлэх**

Харьцуулалт /гэрээний дугаар: **ДБЭХС/202001115**

**Дорнод Бүсийн Эрчим Хүчний Систем ТӨХК** нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогдоос “Тавилга эд хогшил нийлүүлэх” цахим тендерт үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Дэлгэрэнгүй мэдээлэл болон харьцуулалтын баримт бичгийг [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) хаягаар орж авах ба эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр 50,000 төгрөг төлснөөр тендер шалгаруулалтанд оролцож болно.

Үнийн саналыг **[2020 оны 02 дугаар сарын 10 ны өдрийн 14:00 цаг]**-аас өмнө **Тендерийн материалыг Худалдан авах ажиллагааны цахим систем [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) хаягаар өөрийн ААН-ийн хувийн нууцлалын кодыг ашиглан нэвтэрч цахим хэлбэрээр ирүүлнэ.**

Үнийн саналыг нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан **2020 оны 02 дугаар сарын 10 ны өдрийн [14:20]** -т нээнэ.

Үнийн санал ирүүлэхдээ барааны техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг хавсаргасан болно.

Дотоодны давуу эрх тооцно.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Дорнод аймаг, Хэрлэн сум, 1-р баг  
“Дорнод Бүсийн Эрчим Хүчний Систем” ТӨХК-ийн төв байр  
Утас: 70584545, 99102421, 99076484  
Факс: 70584545

## Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- |   |  |
|---|--|
| <b>1. Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа</b> | <b>1.1.</b> Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.   |
| <b>2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт</b>               | <b>2.1.</b> Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.<br><b>2.2.</b> Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.   |
| <b>3. Тендерийн иж бүрдэл</b>                           | <b>3.1.</b> Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:<br>(а) Үнийн санал;<br>(б) Үнийн болон нийлүүлэлтийн хуваарь;<br>(в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;<br>(г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;<br>(д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.]  |
| <b>4. Тогтмол үнэ</b>                                   | <b>4.1.</b> Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана.  |
| <b>5. Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд</b> | <b>5.1.</b> Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.<br><b>5.2.</b> Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ.  |
| <b>6. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа</b>           | <b>6.1.</b> Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш <b>30</b> хоногийн хугацаанд хүчинтэй байна.   |
| <b>7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх</b>            | <b>7.1.</b> Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.<br><b>7.2.</b> Бараа нийлүүлэлтийн хуваарыт заасан бараа нь <b>ТШӨХ-д</b> заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.<br><b>7.3.</b> Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно. |


- 8. Гэрээ  
байгуулах эрх  
олгох тухай  
мэдэгдэл**
- 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь запруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

**Гурав. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ**

ТӨӨЗ-НЫХОЛБОГОХ ЗААЛТ	Шалгуур үзүүлэлт
<b>ТӨӨЗ 1.1</b>	<ul style="list-style-type: none"> <li>➤ <b>2018 оны (аудитаар баталгаажсан) санхүүгийн тайлан, 2019 оны санхүүгийн тайлан</b></li> <li>➤ <b>2018, 2019 онд албан тасалгааны тавилга эд хогшил үйлдвэрлэж, нийлүүлж байсан туршилгатай байх /гэрээгээр гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/;</b></li> <li>➤ <b>Аж ахуй нэгж байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар</b></li> <li>➤ <b>2018, 2019 оны борлуулалтын дундаж орлого 30 сая төгрөгөөс дээш байх</b></li> <li>➤ <b>Татварын албаны тодорхойлолт, татварын ямар нэгэн өргүй байх</b></li> <li>➤ <b>Шүүхийн тодорхойлолт</b></li> </ul> <p>Тендерт оролцогч тухайн ажилд шаардлагатай дараах тусгай зөвшөөрөлтэй байх:</p>
<b>ТӨӨЗ 2.1</b>	<p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь:</p> <p><b>2020 оны 02 дугаар сарын 10 ны өдөр 14 цаг 00 минут</b></p> <p>Тендерийн материалыг Цахим худалдан авах ажиллагааны систем (<a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a>) хаягаар өөрийн ААН-ийн хувийн нууцлалын кодыг ашиглан нэвтэрч цахим хэлбэр (PDF)-ээр илгээнэ. Цахим систем ашиглан илгээх нийт файлын хэмжээ 100 Mb-аас ихгүй байна, нэг файлын хэмжээ 15 Mb-аас ихгүй байна. Цахим тендер шалгаруулалт зохион байгуулах журмын дагуу тендерт оролцох хураамж 50,000 төгрөгийг <a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a>-ээр банкны меркантийн системийг ашиглан төлнө.</p>
<b>ТӨӨЗ 2.1</b>	<p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь:</p> <p>Байгууллагын хаяг: <b>Дорнод аймаг Хэрлэн сум 1 дүгээр баг “ДБЭХС”ТӨХК-ийн төв байр</b></p> <p>Давхар болон өрөөний дугаар: <b>Үйлдвэрийн Б корпус 2 дугаар давхар К-ДХА цехийн даргын өрөө</b></p> <p>Огноо: <b>2020 оны 02 дугаар сарын 10 ны өдөр</b></p> <p>Цаг: <b>14 цаг 20 минут</b></p>
<b>ТӨӨЗ 6.2</b>	Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: <b>Тавилга эд хогшил (бараа) бүхий нэг багцаас бүрдэнэ.</b>

**Гурав. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ**

**1. Барааны тодорхойлолт:**



2020.01.06

№	Материалын нэр	Үзүүлэлт	X/н	Тоо
<i>Албан масалгааны тавилга, эд хогшил</i>				
1	Бичгийн ширээ	MP3-1670 L1600 x W700 x H750mm	ш	9
2	Удирдлагын ширээ	ARTAK VIRANA -VN2190L Хэмжээ: 2135x2050x760 mm	ш	1
3	Оффис сандал	GYM 99221A Black түшлэгтэй, дугуйтай, хөл амраагчтай	ш	9
4	Удирдлагын сандал	EUROBENCH DO9H-BLACK 160 налдаг түшлэгтэй, дугуйтай, хөл амраагчтай	ш	1
5	Бичгийн шүүгээ	EUROBENCH-TB8005GL 1730x800x400 мм	ш	6
6	Хурлын ширээ	Rider-B-CF21010 Хэмжээ: 2100x1000x740 мм	ш	2
7	Түшлэгтэй сандал	TQ B-08-1	ш	16

ХЯНАСАН:

ХҮХ-ИЙН ДАРГА

А. ТӨГСМАНДАХ

БОЛОВСРУУЛСАН:

ТӨСЛИЙН УДИРДАГЧ

Г. ТУЛГА

2. **Стандарт:** Тавилга эд хогшил нь үйлдвэрийн гарал үүслийн бичигтэй, хэрэглэгчийн номтой, хүний биед хор нөлөөгүй, ус чийгний хамгаалалттай байна. Тавилга эд хогшил нь үйлдвэрийн 1 жилийн баталгаатай байна.
3. **Баглаа, боодол:** Тавилга эд хогшил нь үйлдвэрийн сав баглаа боодолтой байна.
4. **Бараа хүргэх газар:** "ДБЭХС" ТӨХК-ийн төв агуулах
5. **Бараа нийлүүлэлтийн хуваарь:** Тавилга эд хогшлыг гэрээ байгуулсанаас хойш 30 хоногийн дотор нийлүүлэх

## Тавилга эд хогшил нийлүүлэлтийн хуваарь

[Захиалагч энэхүү хүснэгтийн 1-7 хүртэлх баганыг, тендерт оролцогч 8 дугаар баганыг тус тус бөглөнө ]

Нэр	Барааны тодорхойлолт	Тооширхэг	Хэмжихн эгж	ТШӨХ-д заасан барааг хүргэх эцсийн цэг (Ажлын талбай)	Инкотермийн нөхцөлийн дагуутогтоосон бараанийлүүлэх хугацаа		
					Бараа нийлүүлэх хамгийн эхний хугацаа	Бараа нийлүүлэх эцсийн хугацаа	Нийлүүлэгчийн санал болгосон хугацаа (Тендерт оролцогч энэ баганыг бөглөнө)
1	2	3	4	5	6	7	8
[Дугаар бичих]	[Барааны товч тодорхойл олтыг бичих]	[нэгжийн то оширхэгийг б ичих]	[Хэмжих нэгжийг б ичих]	[Бараахүргэх газрын нэр]	[Гэрээхүчинтөг өлдөр болсноосх оийших хугацааг б ичих]	[Гэрээхүчинтөгөө лдөр болсноосхой ших хугацааг бичи х]	[Гэрээхүчинтөгөлдө р болсноосхойших хуг ацааг бичих]
1	Бичгийн ширээ	9	ш	“ДБЭХС” ТӨХК- ийн төв агуулах	Гэрээ байгуулсанаас хойш 30 хоногийн дотор нийлүүлэх	Гэрээ байгуулсанаас хойш 30 хоногийн дотор нийлүүлэх	
2	Удирдлагын ширээ	1	ш				
3	Оффис сандал	9	ш				
4	Удирдлагын сандал	1	ш				
5	Бичгийн шүүгээ	6	ш				
6	Хурлын ширээ	2	ш				
7	Түшлэгтэй сандал	16	ш				

## Дөрөв. ЖИШИГ МАЯГТ

### 1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга \_\_\_\_\_ танаа

- Бид, [тандерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг **[санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр]** төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу **[моо]** хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
- Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
- Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Нэр төрөл	Тодорхойло лт	Бараан ы гарал үүслийн улс	Тоо ширхэ г	Нэгж үнэ	Нийт дүн	НӨАТ болон бусад албан татвар	Бүгд дүн
1	2	3	4	5	6	7	8
Тандерийн нийт үнэ							

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тандерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

## 2. НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО ХЭРЭГЖИЖ БУЙ ГЭРЭЭ

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхигүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаарахгүй.

Гэрээний нэр	Захиалагч, холбоо барих хаяг/утас/фак с	Гэрээний үнийн дүн	Гэрээний эхлэх хугацаа	Гэрээний дуусах хугацаа
1.				
2.				
3.				
4.				
5.				
бусад.				

## Тав. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

<b>1. Шалгах болон турших</b>	1.1. Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана.
<b>2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт</b>	2.1. Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ.
<b>3. Оюуны өмчийн эрх</b>	3.1. Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна.
<b>4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх</b>	4.1. Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томьёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно.
<b>5. Баталгаат засварын хугацаа</b>	5.1. Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа [1] жил байна.
<b>6. Гэрээнд өөрчлөлт оруулах</b>	6.1. Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй.
<b>7. Төлбөр</b>	7.1. Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш [14] хоногийн дотор шуурхай хийнэ.
<b>8. Бараа нийлүүлэх хуваарь</b>	8.1. Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө.
<b>9. Алданги оногдуулах</b>	9.1. Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй.
<b>10. Үүргээ биелүүлээгүй-гээс гэрээг цуцлах</b>	10.1. Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна.
<b>11. Маргааныг шийдвэрлэх</b>	11.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана.

## Зургаа. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

- |   |  |
|---|--|
| <b>1. Шалгах болон турших (ГЕН – 1)</b>   | 1.1. [Нийлүүлэгдсэн тавилга эд хогшлыг үйлдвэрлэгчийн сертификатын үзүүлэлтүүдтэй тулгаж хүлээн авна.]   |
| <b>2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН – 2)</b>   | 2.1. Нийлүүлэгчийн бүрдүүлэх тээврийн болон бусад баримт бичгүүд:<br><br>1) нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь;<br>2) барааг хүргэсэн тухай баримт, төмөр замын болон тээврийн баримт;<br>3) үйлдвэрлэгчийн буюу нийлүүлэгчийн баталгаат засварын гэрчилгээ;<br>4) үйлдвэрийн буюу эрх бүхий байгууллагын шалгалтын гэрчилгээ;<br>5) барааны гарал үүслийн гэрчилгээ. |
| <p>Энд жагсаасан баримт бичгийг бараа хүрэлцэн ирэхээс өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна.</p> |  |
| <b>3. Баталгаат засвар (ГЕН-5)</b>  | 5.1. Баталгаат засварын хугацаа 1 жил байна.<br><br>[Гэрээний ерөнхий нөхцөлийн 5 дугаар зүйл нь баталгаат засварын тухай нийтлэг заалтыг агуулна. Энэхүү нийтлэг заалтыг өөрчлөх шаардлага гарвал энд тусгана.]   |
| <b>4. Төлбөр (ГЕН – 7)</b>  | 7.1. Гэрээний ерөнхий нөхцөлийн 7 дугаар зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд:<br><br>Гэрээний үнийн дүнгийн <b>[100]<sup>1</sup></b> хувийг барааг хүлээн авсан акт болон гэрээний ерөнхий нөхцөлийн 2 дугаар зүйлд заасан баримт бичгийг үндэслэн төлнө.  |
| <b>5. Алданги оногдуулах (ГЕН - 9)<sup>2</sup></b>  | 9.1. Алданги оногдуулах хувь: <b>Хугацаа хэтэрсэн хоног тутамд гэрээний үнийн дүнгийн [0,5] хувь</b><br><br>Алдангийн нийт дүн: <b>Гэрээний нийт үнийн [10] хувиас хэтрэхгүй</b>   |

<sup>1</sup>Ихэнхтохиолдолд 100 хувьбайна. Шаардлагатай болтөл борийн хуваарийг геөрчилнэ.

<sup>2</sup> Ихэнхтохиолдолд, нэгдолоо хоногтоног дунгэрээний үнийн алдангийн нийт дунгэрээний үнийн дунгийн 10 хувиастустус хэтрэхгүй.

БАТЛАВ.

ЗАХИАЛАГЧ

(Тамга, тэмдэг)  
(Гарын үсэг)  
(Албан тушаал)

НИЙЛҮҮЛЭГЧ

(Тамга, тэмдэг)  
(Гарын үсэг)  
(Албан тушаал)

[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

..... хот/аймаг

Нэг талаас **[захиалагчийн нэр]** (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас **[нийлүүлэгчийн нэр]** (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож  
\_\_\_\_\_ оны \_\_\_\_\_ сарын \_\_\_\_\_-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

- Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
- Захиалагч нь **[гэрээний нэр, дугаар]-г** (цаашид “бараа” гэх) **[гэрээний үнийг тоогоор болон үсгээр]** (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
- Захиалагч нь барааны нийлүүлэлтийг \_\_\_\_\_ төгрөгийн улсын төсвийн хөрөнгөөр, \_\_\_\_\_ төгрөгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр, \_\_\_\_\_ төгрөгийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
- Нийлүүлэгч нь \_\_\_\_\_ нэр төрлийн барааг \_\_\_\_\_ оны \_\_\_\_\_ дугаар сарын \_\_\_\_\_-наас \_\_\_\_\_ оны \_\_\_\_\_ дугаар сарын \_\_\_\_\_-ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.
- Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;  
Бусад шаардлагатай баримт бичиг<sup>4</sup>;  
Үнийн санал;  
Гэрээний тусгай нөхцөл;

<sup>3</sup> Гэрээбайгуулахүедүүнийгхасна.

<sup>4</sup> Хоёртгалхарилцантохиролцожгэрээнийнөхцөлдоруулсанзайлшгүйшаардлагатайнэмэлт, өөрчлөлтүүд.

Гэрээний ерөнхий нөхцөл;  
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;  
Санхүүжилтийн хуваарь.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвэл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.
7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

#### ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]  
[Гарын үсэг]\_\_\_\_\_

ТАМГА

[Захиалагчийн хаяг]  
[Утас/факсын дугаар]  
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

#### НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]  
[Гарын үсэг]\_\_\_\_\_

ТАМГА

[Захиалагчийн хаяг]  
[Утас/факсын дугаар]  
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]